

- Дулаалгын хавтанцар дээр 3 үе сайн чанарын шавардлага хийнэ. Энэ нь хавтанцар дээр 1 үе торыг нааж торны гаднаас 2 үе шавардлага хийсний дараа хөрсжүүлэлт хийж барзгар гадаргуу үүсгэнэ. Гадна ханыг усан суурьтай эмульсэн будгаар 2 үе будаж, 1 дүгээр фасаданд хэрэглэх будгийг 2 үе будаж, 1 дүгээр давхарын ханын 2.7 метрийн өндөрт жижиг ширхэгтэй чулуун будгаар өнгөлгөө хийнэ. Фасаданд хэрэглэх будгийг MNS5252:2003 стандартын техникийн шаардлагын дагуу чанартай сайн материалыг сонгон хэрэглэх шаардлагатай.

- Хөөсөн фасадны өнцөг булан гэмтэхээс сэргийлж зоолтуур бүхий нимгэн булан суурилуулна. Хананд хэрэглэх торыг 10 см зөрүүлэн наана.

- Мөн одоо байгаа тагтны хавтангийн доод хэсэг, ирмэгүүдийг сайн чанарын гадна ханын эмульсэн будгаар будна.

- Барилгын тагт, цоколын ханын хог шороо, гадаргуу, зарим хэсэгт ил түрхсэн шавардлага зэргийг сайтар цэвэрлэж, тэгш гадаргууг бэлтгэн, зориулалтын будгаар будна.

- Хаалга, цонхны гадна ханатай харьцах хэсгийг шингэн хөөсөн дулаалгаар сайтар чигжиж, амалгаа хийнэ. Энэ ажилд MNS6266:2011 стандартыг мөрдлөг болгоно.

- Барилгын бетон хаяавчийг БМ100 маркийн бетоноор цутгах бөгөөд зураг төслийн дагуу чанартай сайн гүйцэтгэнэ.

### **3. Дээврийн засварын ажил:**

- Дээврийн ажлыг гүйцэтгэхдээ БНБД 31-02-03, БНБД 31-07-05 бусад норм, стандартыг мөрдлөг болгоно.

- Дээврийн ажлыг дулааны улиралд чанарын маш өндөр түвшинд хийж гүйцэтгэх шаардлагатай. Дээврийн ажлыг зураг төсөвт тусгасны дагуу гүйцэтгэнэ.

- Дээврийн хуучирч муудсан хар цаасыг бүхэлд нь хуулж буулган налуулгыг сэргээж 3 см зузаантай бетон тэгшилгээ хийж өгнө. Үүний дээр хөрсжүүлэлт хийж, бекро эласт ЭКП, ЭПП чулуутай болон чулуугүй 2 үе хар цаас нааж өгнө. Нэмэгдэл болон чулуутай хар цаасыг парпед, салхивчийн янданг дагуулан дээш өсгүүлж наана.

- Зурагт үзүүлсний дагуу ханын уулзваруудыг бороо цасны ус нэвтрэхгүйгээр, халуун битум буюу мастик "изол"-оор нүх сүвийг сайтар битүүлж наана.

- Парпед болон салхивчийн сувгийн ханыг шинээр өрж шавардлага хийн шохойн будгаар будна.

### **Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:**

1. Барилгын дээврийн засварын ажлыг зураг төсөв, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсал мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Барилгын дээврийн засварын ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах зэрэг шаардлагатай арга хэмжээг авч гэнэтийн аюул осол гаргахгүй байхаар ажиллана.
4. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана.